



НИСЭХ БУУДЛЫН АЯЛЛЫН ЖУРАМ

B4/PT-TA -2024-01

Edition number 1

Төв аймаг

2024 он

ГАРЧИГ

Бүлэг	Агуулга	Хуудас
	Баталгаажуулах хуудас	
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	
	Нэмэлт өөрчлөлт оруулсан тэмдэглэл	
	Гарчиг	
1-Р БҮЛЭГ	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1	Зорилго	
1.2	Хамрах хүрээ	
1.3	Товчилсон үг, нэршлийн тайлбар	
2-Р БҮЛЭГ	НИСЭХ БУУДЛЫН АЯЛЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
2.1	Ерөнхий мэдээлэл	
2.2	Аяллын төлбөр	
3-Р БҮЛЭГ	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ	
3.1	Үйлчилгээний бүртгэл, захиалга хийх	
4-Р БҮЛЭГ	БЭЛТГЭЛ АЖИЛ БОЛОН БАТАЛГААЖУУЛАЛТ	
4.1	Аяллын баталгаажуулалт	
4.2	Цуцлах	
4.3	Аяллын бэлтгэл ажил	
5-Р БҮЛЭГ	ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ	
5.1	Үйл ажиллагаа зохион байгуулагч хөтчийн үүрэг	
5.2	Аяллын тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг	
5.3	Аюулгүй байдлын хяналт, хамтын ажиллагаа	
5.4	Аялалд үйлчлүүлэгчийн эрх үүрэг	
6-Р БҮЛЭГ	БУСАД ЗҮЙЛ	
6.1	Давагдашгүй хүчин зүйл	
6.2	Онцгой байдлын үед авах арга хэмжээ	
Хавсралт № 1	Аяллын төлбөр	
Хавсралт № 2	Аяллын чиглэл	
Хавсралт № 3	Аялалд үйлчлүүлэгчдийн хориглох болон анхаарах зүйлс	
Хавсралт № 4	Аяллын зөвшөөрлийн маягт	
Хавсралт № 5	Аяллын үйл ажиллагааны зураглал	

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

Энэхүү журмаар “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК (цаашид “НУБИЭ” ХХК гэх) -ийн Нисэх буудлын аяллын үйлчилгээг зохион байгуулах, төлбөр тооцоог бүртгэх, орлого төвлөрүүлэх, үйлчлүүлэгчид журмыг даган мөрдөхтэй холбоотой, аж ахуйн нэгж, иргэнтэй үүсэх харилцааг зохицуулахад (цаашид “Журам” гэх) оршино.

1.2 Хамрах хүрээ

Нисэх буудлын аяллын үйлчилгээний үйлчлүүлэгчид болон аяллыг зохион байгуулахад оролцож буй ажилтнуудын хооронд үйл ажиллагаа явуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3 Товчилсон үг, нэршлийн тайлбар

- “НУБИЭ” ХХК - “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК;
- ЧХОУНБ – Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудал
- ЗТБ – Зорчигч терминалын барилга.
- ЗТБЦЦ – Зорчигч терминалын барилгын цугларах цэг.
- ЗУГ- Захиргаа удирдлагын газар
- ШУХТ- Шуурхай удирдлага хяналтын төв
- АБХТ-Аюулгүй байдлын хяналтын төв
- “Төлбөр тооцооны систем” – Нисэх буудлын аяллын бүртгэл мэдээлэл, төлбөрийн тооцооллыг боловсруулж, И-баримт илгээх программ хангамж бүхий цогц систем;
- Хамтран ажилладаг байгууллага – Төрийн тусгай чиг үүргийн болон салбарын төрийн зохицуулалтын байгууллага, агаарын тээвэрлэгч компаниуд, түрээслэгч байгууллагууд, аяллын зохион байгуулахад хамтран оролцох НУБИЭ ХХК-ийн дотоод газар, хэлтэс;
- Үйлчлүүлэгч – Нисэх буудлын аяллаар үйлчлүүлэх иргэд, хамт олон;
- Яаралтай тусламжийн байгууллагууд – Гал түймэр, гамшиг, осол, аврах ажиллагаа, гэмт хэрэг зөрчил, зам тээврийн осол, эмнэлгийн түргэн тусламжийн чиглэлийн байгууллагууд;

2. НИСЭХ БУУДЛЫН АЯЛЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Ерөнхий мэдээлэл

- 2.1.1. Аяллын үйлчилгээ нь /Хавсралт №2/-д заасны дагуу Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул, 41090 Тахилт толгойд байрлах “Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудал”-ын аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд зохион байгуулагдана.
- 2.1.2. Аялалд хамрагдах хамгийн бага үйлчлүүлэгчийн тоо 15 байх бөгөөд түүнээс цөөн үйлчлүүлэгч бүртгүүлсэн тохиолдолд тухайн аяллыг цуцалж дараагийн аялалд шилжүүлнэ.
- 2.1.3. Аялал нисэх буудлын зорчигч терминалын барилгын цугларах цэгээс эхэлж /Хавсралт №2/-д заасан чиглэлийн дагуу аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд

зохион байгуулагдаж, зорчигч терминалын барилгын цугларах цэгт буцан ирснээр дуусна.

- 2.1.4. Аяллын нийт үргэлжлэх хугацаа 2 цаг 40 мин байна.
- 2.1.5. Аяллын мэдээлэл болон бүртгэлийг ЧХОУНБ-ын цахим хуудсаар дамжуулан хийнэ.
- 2.1.6. Аялал нь энгийн болон групп аялагчдаас бүрдэнэ. Үйлчлүүлэгчдийн төрлийг /Хавсралт №1/-аас харна уу.
- 2.1.7. Энгийн аялал гэдэг нь хоорондоо хамааралгүй бие даан оролцох боломжтой үйлчлүүлэгчдээс бүрдсэн аяллыг хэлнэ.
- 2.1.8. Групп аялал гэдэг нь хоорондоо хамааралтай нэг бүлгийн 20 үйлчлүүлэгчдээс бүрдсэн аяллыг хэлнэ. Үүнд: Байгууллага болон сургуулийн сурагчид, сонирхлоороо нэгдсэн бүлэг байна.
- 2.1.9. Групп үйлчлүүлэгчдийн хувьд аяллын бүртгэлийн мэдээллийг ЧХОУНБ-ын цахим хуудас болон аялал зохион байгуулагчтай шууд холбогдон авах боломжтой.
- 2.1.10. Групп үйлчлүүлэгчдийн хувьд аяллын эхлэх, дуусах цэгийг Улаанбаатар хотоос эсвэл Нисэх буудлаас гэсэн сонголтуудаас хийх боломжтой. Үнийн мэдээллийг /Хавсралт №1/-аас харна уу.
- 2.1.11. Ерөнхий боловсролын сургуулийн нэг ангийн 20-оос дээш сурагчдыг нэг групп гэж үзэх ба аяллыг удирдаж буй үндсэн эсвэл туслах багшийг төлбөргүйгээр оролцуулна.

2.2 Аяллын төлбөр

- 2.2.1 Аяллын төлбөрийг НУБИЭ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан тарифаар тооцох бөгөөд тарифыг журамд хавсарган мөрдөнө.
- 2.2.2 Аяллын төлбөрийг /Хавсралт №1/-д тусгасан дүнгээр тооцно.
- 2.2.3 Төлбөр тооцооны систем аяллын бүртгэл, захиалгад үндэслэн тарифын дагуу автоматаар тооцооллыг хийнэ.

3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ

3.1. Үйлчилгээний бүртгэл, захиалга хийх

- 3.1.1 Аяллын захиалгыг ЧХОУНБ-ийн цахим хуудасны /<https://www.ulaanbaatar-airport.mn/> төлбөр тооцооны цахим системийг ашиглан урьдчилан захиална.
- 3.1.2 Аяллын үйлчлүүлэгчдийн тоо бүрдсэн тохиолдолд аяллын бүртгэл хаагдаж дараагийн аяллыг сонгох боломжтой.
- 3.1.3 Аяллын захиалга цуцалсан тохиолдолд аяллын бүртгэл идэвхгүй болох бөгөөд өөр өдрийг сонгох боломжтой.
- 3.1.4 Аяллын цахим төлбөр тооцооны системийн дагуу холбогдох мэдээллийг бүрэн бөглөж бүртгэлийг хийнэ.
- 3.1.5 Аяллын бүртгэлд нэг үйлчлүүлэгч хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгчийг бүртгүүлэх боломжтой бөгөөд холбогдох мэдээллийг үнэн зөв бөглөнө.
- 3.1.6 Аяллын үйлчлүүлэгч бүр аяллын /Хавсралт №3/-т (Хориглох болон анхаарах зүйлс) заасан нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байна.

4. БЭЛТГЭЛ АЖИЛ БОЛОН БАТАЛГААЖУУЛАЛТ

4.1. Аяллын баталгаажуулалт

- 4.1.1. Үйлчлүүлэгч аяллын товлогдсон өдрөөс хуанлийн 2 (хоёр) өдрийн өмнө "НУБИЭ" ХХК-ийн Голомт банкны 812 510 2639 тоот дансанд төлбөрийг бүрэн хийснээр тухайн захиалга баталгаажна.
- 4.1.2. Хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгчдийг нэг үйлчлүүлэгч бүртгүүлсэн тохиолдолд бүртгэлийн систем төлбөрийг нийт дүнгээр тооцно.
- 4.1.3. Төлбөрийн сонголтууд:
 - Social pay
 - QR код Q-Pay
 - Дансны хоорондын шилжүүлэг
- 4.1.5 Аяллын төлбөр хийгдсэнээс хойш 24 цагийн дотор бүртгүүлсэн (и-мэйл) цахим хаягаар аялал баталгаажсан баримт илгээгдэнэ.

4.2 Цуцлах

- 4.2.1 Тус журмын 2 дугаар бүлэг 2.1.2 зүйл болон 6 дугаар бүлгийн 6.1 дүгээр зүйл заалтад дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд аяллыг цуцална.
- 4.2.2 Аялал цуцлагдах тохиолдолд аяллын үйлчлүүлэгчдэд бүртгүүлсэн утас эсвэл (и-мэйл) цахим хаягаар эргэн мэдэгдэнэ.
- 4.2.3 Аялал цуцлагдсан тохиолдолд аяллын өдрийг өөрчлөн дараагийн аяллын товлогдсон өдөрт шилжүүлнэ.
- 4.2.4 Үйлчлүүлэгч аяллын огноог өөрчлөх боломжгүй бөгөөд зайлшгүй тохиолдолд төлбөрийг буцаан олгож захиалгыг цуцална.

4.3. Аяллын бэлтгэл ажил

- 4.3.1. Аяллын мэдээллийг шалган баталгаажуулж, аяллын товыг холбогдох газар, хэлтэс, хамтран ажиллах байгууллагуудад мэдэгдэх, зөвшөөрлийг авах, зохион байгуулалтын ажлыг хийж аяллын аюулгүй байдал болон бэлтгэлийг хангана. /Хавсралт №5 харна уу/
- 4.3.2. Аяллын өдрийн тов болон эхлэх, дуусах хугацааг ШУХТ-аас баталгаажуулж тухайн өдрийн нислэгийн мэдээлэлтэй уялдуулна.
- 4.3.3. Аялал зохион байгуулагчид нь аялалд хэрэглэгдэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, аюулгүй байдлын хэрэгслүүдийн бэлэн байдлыг хангана.
- 4.3.4. Аялал эхлэхээс 2 /хоёр/ цагийн өмнө аяллын эхлэх цэг дээрх аюулгүй байдлыг хангаж, туузан шонгуудыг байршуулна.

5. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1 Үйл ажиллагаа зохион байгуулагч хөтчийн үүрэг

- 5.1.1. Хөтөч нь аяллын жолооч аюулгүй байдлын зааварчилгаа авсан эсэх аялалд үйлчлэх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан эсэхийг шалгаж энэ талаар ЗУГ-ын Захиргааны хэлтсээс тодруулан баталгаажуулна.
- 5.1.2. Хөтөч тухайн өдрийн аялалд хамрагдахаар баталгаажуулсан аялагчдын ирцийг бүрэн эсэхийг шалгана.

- 5.1.3. Хөтөч аялал эхлэхээс 1 /нэг/ цагийн өмнө үйлчлүүлэгчдийн нэр болон бусад шаардлагатай мэдээллийг бүрдүүлж /Хилийн цэргийн 0218 дугаар анги/-аас хамгаалагдсан бүсэд нэвтрэх нэг удаагийн үнэмлэхийг авсан байна.
- 5.1.4. Үйлчлүүлэгч цагаасаа хоцорсон тохиолдолд бүртгэлтэй утасны дугаарт аялал эхлэхийг мессеж болон утсаар мэдэгдэнэ.
- 5.1.5. Хөтөч нь үйлчлүүлэгчдэд /Хавсралт №3/ -т заасан хориглох болон анхаарах зүйлсийн талаар мөн нисэх буудлын аюулгүй байдлын дүрэм, журам, хориглосон эд зүйлсийн талаарх зааварчилгааг өгч маягтад гарын үсэг зуруулан баталгаажуулна.
- 5.1.6. Хөтөч нь үйлчлүүлэгчдээс хориглосон эд зүйлс биед байгаа эсэхийг тодруулан хэрэв байгаа тохиолдолд тухайн эд зүйлсэд аюулгүй байдлын үзлэг шалгалтыг хийлгэн олсон, гэсэн эд зүйлс хадгалах хэсэгт аяллын хугацаанд түр хадгалуулна.
- 5.1.7. Хөтөч нь үйлчлүүлэгчдийг бүртгэж шаардлагатай бүх зааварчилгааг өгсний дараа аяллын автобус руу хөтөлнө.
- 5.1.8. Хөтөч үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 5.1.9. Аяллыг хуваарийн дагуу цаг хугацаанд нь зохион байгуулна.
- 5.1.10. Аяллын талаарх мэдээлэл заавар, зөвлөгөөг аялалд үйлчлүүлэгчдэд өгнө. Үүнд: Аяллын маршрут, цаг агаарын байдал, зөвлөгөө, анхааруулга, унаа зохицуулалт гэх мэт.
- 5.1.11. Хөтөч аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон хэвийн ажиллагаанд хяналт тавьж бэлэн байдлыг ханган ажиллана.
- 5.1.12. Хөтөч ажилтнууд болон үйлчлүүлэгч нь нисэхийн аюулгүй байдлын шаардлагыг мөрдөж, цацруулагч хантаазыг өмсөж үнэмлэхийг ил харагдахаар зүүсэн байна.
- 5.1.13. Хөтөч аяллын турш "Аяллын заавар" болон "Нисэх буудлын үйлчилгээний ажилтны заавар"-ыг тус тус мөрдөн ажиллана.
- 5.1.14. Аяллын үйлчлүүлэгч /Хавсралт №3/-т заасан зүйлсийг дагаж мөрдөөгүй тохиолдолд журмын дагуу хөтөч нь аяллыг зогсоож аюулгүй байдал хамгаалалтын албаны ажилтнаар зөрчил гаргасан этгээдийг нисэх буудлын хамгаалагдсан бүсээс гаргуулна.
- 5.1.15. Аюулгүйн хамгаалагдсан бүсэд тээврийн хэрэгслээс үйлчлүүлэгчдийг буулгахыг хориглоно.

5.2 Аяллын тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг

- 5.2.1. Аяллын тээврийн хэрэгслийн жолооч нь "Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх жолооч операторчны сургалт"-д хамрагдсан байна.
- 5.2.2. Аяллыг /Хавсралт №2/-т заасан чиглэлийн дагуу нисэх буудлын аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд гүйцэтгэнэ.
- 5.2.3. Аяллын турш тээврийн хэрэгслийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж бэлэн байдлыг ханган ажиллана.
- 5.2.4. Аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцохдоо нислэг үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саад учруулахгүй, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ШУХТ-ийн нисэх буудлын ээлжийн менежер болон газрын үйл ажиллагаа зохицуулагч нартай тасралтгүй харилцааны радио (гар станц) холбоогоор мэдээллийг өгч, чиглэл авч ажиллана.
- 5.2.5. Аюулгүйн хамгаалагдсан бүсүүдэд тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцохдоо хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.

- 5.2.6. Аюулгүйн хамгаалагдсан бүсийн апрон талбайд тээврийн хэрэгслээс үйлчлүүлэгчдийг буулгахыг хориглоно.

5.3 Аюулгүй байдлын хяналт, хамтын ажиллагаа

- 5.3.1 Аяллын үйлчлүүлэгч А-31 нэвтрэх цэгээр аюулгүй байдлын хамгаалагдсан бүсэд нэвтрэх бөгөөд НБЕЗ-ын 2.3 “Аэродромын үйл ажиллагааны бүсэд нэвтрэх журам” болон “ЧХОУНБ-ын “Аюулгүй байдлын хөтөлбөр”-ийн 5.6.3-т заасны дагуу аюулгүй байдлын үзлэгт хамрагдан нэвтэрнэ.
- 5.3.2 Аяллыг батлагдсан маршрутын дагуу технологийн замаар үйлдэх бөгөөд “Перроны удирдлага, зохицуулалт” журмын дагуу ШУХТ-ийн үйл ажиллагааны зохицуулагчаас холбогдох зөвшөөрлийг авч үйлдэнэ. /Хавсралт 3 харна уу/
- 5.3.3 Аюулгүйн хамгаалагдсан бүсэд хөдөлгөөн үйлдэхдээ “Аэродромын хөдөлгөөнт бүсийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм”-ийг мөрдөн зорчино.

5.4 Аяллын үйлчлүүлэгчийн эрх үүрэг

- 5.4.1 Нисэх буудлын цахим хуудсаар аяллын захиалгаа баталгаажуулахын өмнө санамж, анхааруулгатай танилцаж, зөвшөөрсөн байна. /Хавсралт №3 харна уу/
- 5.4.2 Аяллын үйлчлүүлэгчид нь аялалд оролцохоос өмнө “Аяллын үйлчлүүлэгчийн хориглох болон анхаарах зүйлс” -тэй /Хавсралт №3 / танилцан дагаж мөрдөхийг зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

6. БУСАД ЗҮЙЛ

6.1 Давагдашгүй хүчин зүйл

- 6.1.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлс /Гал, ус, гамшигт үзэгдэл/ тохиох үед арга хэмжээг хойшлуулах эсвэл цуцалж болно. Энэ тохиолдолд аяллын өдрийг өөрчлөн үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангана.
- 6.1.2. Халдварын нөхцөл байдал үүсэж, Засгийн газрын тогтоол гарч онцгой байдал зарласан үед тухайн аяллыг цуцалж болно.
- 6.1.3. Нисэх буудлын үйл ажиллагаанаас шалтгаалан гэнэтийн зайлшгүй шаардлага тулгарсан үед арга хэмжээг хойшлуулж цуцалж болно. /Жишээ нь: Хүний болон техникийн хүчин зүйлээс болж аэродромын талбайд гэмтэл эрсдэл учирсан үед/

6.2 Болзошгүй нөхцөл байдал гарсан үед авах арга хэмжээ

- 6.2.1 Аяллын үед тээврийн хэрэгсэлд гэмтэл үүсэх, осол гарсан үед тээврийн хэрэгслийн жолооч ШУХТ-ийн Газрын үйл ажиллагаа зохицуулагч болон нисэх буудлын ээлжийн менежер тэр даруй мэдэгдэн зааварчилгаа авч ажиллана.
- 6.2.2 Аяллын үйлчлүүлэгч гэнэтийн осолд өртөж гэмтэл учрах, эрүүл мэнд гэнэт муудах тохиолдолд яаралтай ШУХТ-ийн Газрын үйл ажиллагаа зохицуулагч, нисэх буудлын ээлжийн менежер болон ЗҮХ-ийн эмнэлгийн хэсэгт дуудлага өгч /Утас:8505 0568; 7128 7333/ анхан шатны тусламжийг үзүүлнэ.

Аяллын тариф

Энгийн

(НӨАТ-орсон ₮)

	Үйлчлүүлэгчийн төрөл	Эхлэх цэг /Нисэх буудал/ Төлбөр
1	Том хүн /18 наснаас дээш/	40,000.0 ₮
2	Хүүхэд /11 наснаас дээш/	20,000.0 ₮


*6-11 хүртэлх настай хүүхэд асран хамгаалагчийн хамт оролцох ба тарифын дагуу хүүхдийн төлбөрийг төлнө. Энэ тохиолдолд асран хамгаалагч уг тарифын дагуу том хүний төлбөрийг төлж оролцоно.

Групп /Хөнгөлөлт – 10%/

(НӨАТ-орсон ₮)

	Үйлчлүүлэгчийн төрөл	Эхлэх цэг- Нисэх буудал	Эхлэх цэг-Улаанбаатар хот /Тээвэрлэлт багтсан/
1	Том хүн /18 наснаас дээш/	36,000.0 ₮	54,000.0 ₮
2	Хүүхэд /11 наснаас дээш/	18,000.0 ₮	27,000.0 ₮

Аяллын чиглэл /Эхлэх цэг Нисэх буудал/



Аяллын үйлчлүүлэгчийн хориглох болон анхаарах зүйлс

- 1) Үйлчлүүлэгчид аяллын явцад хөтчөөс тусгайлан зөвшөөрөл аваагүй тохиолдолд ямар нэгэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон бусад зүйлд хүрч болохгүй. Олон тооны тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй зохих ёсоор харьцахгүй бол хүнд гэмтэл авах, бүр үхэлд хүргэж болзошгүйг анхаарна уу.
- 2) Үйлчлүүлэгчид хөтчийн мэдээлэлд бүрэн анхаарал хандуулах ба бага насны хүүхдүүдийн зарим үйлдэл нь аяллын оролцогчдын анхаарлыг сарниулж болзошгүй тул эцэг эх, асран хамгаалагчид анхаарч бусдад төвөг учруулахгүйгээр үйлчлүүлнэ.
- 3) Зохион байгуулагч нь дараах зүйлүүдэд хариуцлага хүлээхгүйг анхаарна уу.
 - Ослын улмаас гэмтсэн тохиолдолд;
 - Мартагдсан эсвэл алдагдсан эд зүйлс;
- 4) Аялалд 1-5 насны хүүхдүүд оролцуулах боломжгүйг анхаарна уу.
- 5) Аялалд 6-11 насны хүүхдүүд зайлшгүй эцэг эх, асран хамгаалагчийн хамт оролцоно.
- 6) Аяллын цагаас хоцорсон тохиолдолд аялалд оролцох боломжгүйг анхаарна уу.
- 7) Үйлчлүүлэгчид аяллын турш хөтөчтэй хамт байна. Эцэг эх /асран хамгаалагч/ нь хамт яваа хүүхдүүдээ хараа хяналтгүй орхихыг хориглоно.
- 8) Архи бүх төрлийн согтууруулах ундаа хэрэглэх болон хэрэглэсэн үйлчлүүлэгч оролцохыг хориглоно.
- 9) Галын аюулгүй байдлыг хангах үүднээс нэг цэгээс нөгөөд шилжихэд тамхи татах, ил задгай хог хаях, ил гал гаргахыг аяллын турш хориглоно.
- 10) Нисэх буудлын аяллын үеэр дараах зүйлийг хориглоно:
 - Үйлчлүүлэгч ямар нэгэн зөвшөөрөл авснаас үл хамааран зэвсэг (Хурц иртэй зэвсэг болгон ашиглах боломжтой бүх зүйл, гэх мэт) авч явах.
 - Гааль, хилийн тухай хууль тогтоолоор хориглосон аливаа зүйлс.
- 11) Үйлчлүүлэгч аяллын хугацаанд нисэх буудлаар үйлчлүүлж буй зорчигч, үйлчлүүлэгч, ажилтан, агаарын тээвэрлэгч, төрийн байгууллагын ажилтнуудын ажилд саад учруулахыг хориглоно.
- 12) Үйлчлүүлэгч агаарын хөлөг, дүрэмт хувцастай ажилчид болон төрийн байгууллагын логог зөвшөөрөлгүйгээр зураг авах, бичлэг хийх, олон нийтийн сүлжээнд нийтлэхийг хориглоно.
- 13) Аялалд оролцохдоо нисэх буудлын ажилтанд саад учруулахгүй байх, эдгээр газруудад гүйх, чанга дуу авиа гаргахыг хориглоно.
- 14) Зөвхөн хөтчийн заасан байршилд зураг авах бөгөөд бусад газарт гэрэл зураг авахыг хориглоно.
- 15) Үйлчлүүлэгчдийн тоо хамгийн бага түвшинд хүрээгүй тохиолдолд тухайн аяллыг хойшлуулах бөгөөд дараагийн аялалд шилжүүлнэ. Энэ тохиолдолд аялал эхлэхээс 1 хоногийн өмнө аяллын үйлчлүүлэгчид тухай бүр мэдэгдэнэ.

☐ Дээрх бүх нөхцөлийг зөвшөөрч байна

Огноо:

Нэр (Овог, Нэр):

Гарын үсэг:

Байгууллагын нэр:

Үйлчлүүлэгчийн төрөл: ☐

Энгийн

☐

Групп



НИСЭХ БУУДЛЫН АЯЛЛЫН ЖУРАМ

Хавсралт №4

Аяллын зөвшөөрлийн маягт

	АЯЛЛЫН ЗӨВШӨӨРӨЛ Airport tour application Form	Огноо/Issue date	2024..
		Number	
		Other area	

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ / GENERAL			
Нисэх буудлын аялал хийх зөвшөөрөл хүссэн газар: Түрээс эср сурталчилгааны хэлтэс /Name of Applicant airport tour/: Tenant and Advertisement division			
Аяллын оролцогчдийн хэлбэр: Types of tour participants:		☐ Бүлгийн аялал Group Participants.	☐ Ганцаарчилсан аялал Single Participants
Хариуцах газар, хэлтсийн мэдээлэл: Зорчигч терминалын газар – Түрээс, эср сурталчилгааны хэлтэс /Responsible Department and Division: Passenger terminal department – Tenant and advertisement division			
Аялал зохион байгуулах ажилтнуудын мэдээлэл /Information from tour guides/	Хүмүүсийн нэр /Names/	Албан тушаал /Position/	Холбоо барих утас /Registration number, Contact number/
Зорчигч терминалын газар Түрээс эср сурталчилгааны хэлтэс /PT- TA/	Б.Төгөлдөр	Тур аяллын хөтөч /Guide/	85050548
		Хавсралт ашигласан эсэх /Check if an attached table is used/ ☐	
эхлэх огноо: 2024 ____ / Date of start/			
Байршил: Маршрутын дагуу нисэх буудлын хамгаалагдсан бүсүүдэд /Location of photo shooting/ In the restricted areas of the airport along the route			
Аялал хамтран зохион байгуулах газар, хэлтэс: /tour co-organization Department - Division /:			
☐	Нисэх буудалд аялал хийх хүсэлт, албан тоот /Хувь хүн, Аж ахуйн нэгж/ Аяллын оролцогчдын нэрсийн жагсаалт регистрийн дугаар, холбогдох утасны дугаар Бүлэг аяллын нэрсийн жагсаалт, регистрийн дугаар, холбогдох утасны дугаар Аялалын маршрут, дэлгэрэнгүй хөтөлбөр AOD – /AO-AO, AO-SS, AO-FF/		
☐	Аэродромын газар – Аэродромын хэлтэс /ADD-AD/		
☐	Газрын үйлчилгээний газар – Газрын үйлчилгээний төлөөлөлтийн хэлтэс, Төлбөйг үйлчилгээний хэлтэс GHD – /GH-RH, GH-DA/		
☐	Зорчигч терминалын газар – Түрээс, эср сурталчилгааны хэлтэс PTD – /PT-TA/		
2. АЯЛАЛ ХИЙХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ / DOCUMENTS TO BE ATTACHED /			
- Нисэх буудалд аялал хийх хүсэлт, албан тоот /Хувь хүн, Аж ахуйн нэгж/ - Аяллын оролцогчдын нэрсийн жагсаалт регистрийн дугаар, холбогдох утасны дугаар - Бүлэг аяллын нэрсийн жагсаалт, регистрийн дугаар, холбогдох утасны дугаар - Аялалын маршрут, дэлгэрэнгүй хөтөлбөр		- An official request for tour at the airport - Copies of corporate registration certificate - Copies of ID card of all participants and the list of participant name - Detailed plan of tour (including the area and destination etc)	
3. ЗӨВШӨӨРӨЛ / APPROVAL/			
Зөвшөөрөл өгсөн /Permitted by/ Head of PTD	Нэр /Name/ Tomizawa Osamu	Гарын үсэг/тэмдэг /Signature/	
if the shooting is taken place in airside and/or restricted area /Checked by/ Safety & Security Dept	Нэр /Name/ Azhibay A.	Гарын үсэг/тэмдэг /Signature/	
4. ХЯНАЛТЫН ХЭСЭГ /CONTROL SECTION/			
Аяллын явцад зөрчил гарсан эсэх / Is there a conflict?:	Тийм/Yes	Үгүй/No	Тайлбар/ Note: Гарын үсэг/Sign/Tenant and advertisement Division/

Хэвлэлийн дугаар: Огноо:2024.05.17

Хяналтын дугаар:

Нэмэлт өөрчлөлтийн дугаар: Огноо:

Хуудас 14